

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР БИОЛОГИЙН  
БАГШ БАТТӨР ОВОГТОЙ АРИУНБАЯРЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Төлөвшил**

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал
  - Хичээлийн жилийн нээлтийн үйл ажиллагаанд Багш хөгжлийн төвийн самбарыг хариуцаж шинэчилсэн.
  - “Нэг баг нэг арга зүй” багш нарын уралдаанд нийт залуу багш нарын хэмжээнд Шилдэгийн шилдэг ур чадвартай багшаар шалгарсан.
  - Багш нарын баярыг угтсан буухиа тэмцээнд хамт олонтойгоо оролцсон.
  - Улаан-Үдэ хотын Итгэлт хамбад хамт олны хамтаар аялаад ирсэн аялал маш сайхан болсон.
  - Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулан хамт олноо хөгжөөх зорилготой хунгийн бүжиг бүжиглэсэн. Мөн урлаг заалыг чимэх ажлын багт орж ажилласан
  - Голомт банкнаас зохион байгуулсан санхүүгийн боловсрол сургалтанд хамрагдаж үүнийгээ олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн байгаа.
  - Мөсөн хотхон болон гадаа мод чимэглэх үйл ажиллагаанд оролцсон.
  - Хэлний наадмын үйл ажиллагаанд зохион байгуулагч багшаар оролцсон
  - Чингэлтэй Дүүргийн биологийн судлагдахууны тайланг бичиж нэгтгэсэн.
2. Дадал хэвшил
  - Нийт хичээл ордог ангийн сурагчид, эцэг эхтэй сургууль дээр мөрдөх үйл ажиллагааны дэгүүдийг нэг бүрчлэн танилцуулж ангид орж ирэхдээ Гар утсаа унтраан цүнхэндээ хийсэн байх, Багшийг орж ирэхэд хүндэтгэлтэйгээр мэндэлж хичээлээ эхэлдэг болсон.
3. Зан чанар
  - Багшийг хичээлээ заахаар орж ирэхэд самбараа арчиж бэлдсэн байх
  - Багштай хичээлийн заахад ангиа бэлэн болж , эмх цэгцэнд ороод мэндэлдэг болсон
  - Гэрийн даалгаврыг тогтмол хийж сургасан.
  - Хичээлийн дэгийг тохиролцож сайн баримталдаг болсон
  - Багш самбарт хичээл зааж байхад өөртөө болон бусдад саад болохоо больсон. Бие биеэ хүндэлж , сонсож сурсан, Хэний зөв буруу болохыг ялгаж сурах. Бие биедээ зөв шаардлага тавьж алдааг нь хэлж өгч байх Багш ажилчдыг хүндэлж харилцах
4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал
  - ДОХ-н өдөрт зориулсан дэвжээ тэмцээн болон усны өдөрт зориулсан дэвжээ тэмцээнүүдэд хичээл ордог ахлах ангийн сурагчдаа амжилттай бэлдэн оролцуулж мөнгөн медал болон шагналт байруудыг эзэсэн.
5. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал
  - Сонгон судлах хичээлийн судалгаа хийгдэж түүний дагуу хүүхдүүд Биологийн хичээлийг сонгох цагаар хуваарийн дагуу орж хэвшсэн байгаа.
  - Мөн ЭЕШ өгөх сурагчдаас ажил мэргэжлийн чиг баримжаа тодорхойлох судалгаа авч нэгтгэн үр дүнгийн дагуу ажил байдлаа тодорхойлон ажиллаж байна.
6. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн
  - Багш-эцэг эх-сурагчийн хичээл хамтын үйл ажиллагааг зохион байгуулан сард нэг удаа эцэгэхийг өөрийн заадаг хичээлд урилгаар оролцуулдаг болсон.
  - Сурагчид сургуулийн орчинд мөрдөх дэгийг хэрэгжүүлэхэд, Цахим орчинд ухаалаг соёлтой байхад, сургуулийн орчинд хориотой хоол хүнс хэрэглэхгүй хэвшихэд эцэг эхийн туслалцаа, оролцоог маш их хэмжээгээр авч үр дүнд хүрсэн амжилттай.
  - Эцэг эхийн анхдугаар зөвлөгөөн , эцэг эхчүүд илтгэл бэлтгэн бусад эцэг эхчүүд болон багш нартаа санаа бодлоо хуваалцсан үр дүнтэй ажил болсон.

- Эцэг эхийн нээлттэй хаалганы үйл ажиллагаанд 100% ирцтэй оролцсон.
- 7. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт
  - Хүүхэд хамгаалал ёс зүйн гэрээг мэргэжлийн багшийн зүгээс хэвлэж аван даган мөрдөж ажиллаж байна.
- 8. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт
  - Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаанд нийт хичээл ордог сурагчидаа тэгш хамруулсан. Зөв дадал хэвшилд уриалсан санал зөвлөмжөөр зөвөлгөө өгсөн. Зөв хандлагад чиглүүлсэн, сонирхол өрнөхүйц мэдээ мэдээллээр ханган ажилласан. Багаар болон бие даан асуудал шийдвэрлэх ур ухаанд чиглүүлсэн. Цагийг үр дүнтэй ,зөв хуваарьлалттай ажиллаж сурах үйл ажиллагаанд сургасан.

#### I. Мэдлэг чадвар ахиц, амжилт

10-дугаар ангийн 223 сурагч дүгнэгдэхээс 207 сурагч дүгнэгдсэн. 10-р ангийн сурагчдын хувьд сонгох даалгавар оруулаагүй 5 задгай даалгавар боловсруулан 1-р даалгавар сэргээн санах төвшний даалгавар байсан бөгөөд 9-р ангийн агуулгыг багтаан оруулсан. Эсийн үйл ажиллагаа сэдвээр зураг дээр заах даалгавар боловсруулан эсийн органомдуудыг нэрлэх ажил байсан. Даалгаварыг сурагчид маш сайн хийсэн нь агуулгаа сэргээн санах харьцуулах чадвар сайн байна гэж дүгнэж байна.

2-р даалгавар ангилал зүйн сэдвийг оруулсан бөгөөд латин нэршилийг зөв холбох ажил байсан ба мэдлэг ойлголтын төвшний даалгавар байсан.сурагчид дийлэнхи нь хангалттай сайн хийсэн бөгөөд зарим сурагчид андуурч холбож байсан. Энэ даалгавар бага зэрэг хүндэдсэн байсан. Энэ бүлгийн хичээлийг дахин бүлэг бүрд давтах шаардлагатай үүнийг анхаарах.

3-р даалгавар Мөн мэдлэг ойлголтын төвшинг шалгасан байсан бөгөөд цэгийн оронд нөхөх даалгавар байсан. Эсийн химийн найрлага сэдвээр боловсруулсан. Сурагчид даалгаварыг хангалтгүй хийсэн нь уншиж бэлдээгүй байсан нь харагдаж байсан. Мөн энэ сэдвийн даалгавар хүндэдсэн байж магадгүй гэж дүгнэлээ.

4-р даалгавар задлан шинжлэх төвшиний даалгавар байсан бөгөөд зураг дээр ажиллах даалгавар байсан. Байгаль дахь бодисын эргэлт сэдвээс даалгавраа боловсруулсан. Сурагчид энэ даалгаварыг харьцангуй сайн гүйцэтгэсэн.

5-р даалгавар Хэрэглээний төвшний даалгавар оруулсан бөгөөд туршилт ажлын үр дүнг тооцоолж бичих байсан. Энэ даалгавар дээр сурагчид тааруу хийсэн нь хэрэглээний төвшний даалгаварууд дээр сурагчид ажиллах чадвар сул энэ талын даалгаврыг даалгаврын сандаа багш нар тусгадаггүй иймэрхүү даалгаврууд дээр сурагчид ажиллаж сураагүй нь харагдаж байсан. 10-р ангийн бүлгийн хувьд 10а анги хамгийн сайн гүйцэтгэлтэй 67% гүйцэтгэж 10-дугаар ангиудаа тэргүүлээ. Дараагийн сайн хийсэн анги 10б бүлэг 62% гүйцэтгэлтэй. 10в бүлэг гүйцэтгэл 40.6% 10г бүлэг 39% тай байсан нь энэ анги хагас жилийн мэдлэг чадварын шалгалтандаа хангалтгүй бэлтгэж орсон нь харагдаж байна.Цаашид даалгаварын тавил болон агуулга руу илүү анхаарч ажиллах болно

Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /MOODLE/

- 10-дугаар ангийн Биологий 3-дугаар улиралын 2 нэгж болон ээлжит хичээлүүдийг боловсруулж баталгаажуулан Мүүдэлд байрлуулсан Энэ сэдвүүдтэй уяалдуулан 7 тестийг бэлтгэн хийсэн, тестүүдын дагуу жишиг даалгаварыг хийж өгсөн байгаа.

- 4-улиралын 2 нэгж хичээлийг Мүүдэлд байрлуулан жишиг даалгаварыг бас хийж өгсөн байгаа Стандарт хэрэгжилт

#### 1. Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт

- 23-сургуулийн шинээр хэрэгжүүлж буй Мүүдл системийг эзэмшиж сургалтандаа ашиглаж байгаа.

- Өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр солонгос болон англи хэлний дамжаанд ажлын бус цагаар суралцаж байна.
  - Багш бүрийн заавал унших номоос ногоон нүдэн лам, болон Самар хатан романыг уншиж зорилгоо биелүүлсэн.
  - Зааж бүй бүлгийн Жишиг даалгаварыг нийслэлийн боловсролын газрын сайтаас татан авч өөрөө эхэлж ажиллан дараа сурагчиддаа давтлага хэлбэрээр чанартай зааж эзэмшүүлэхэд зорилгоо болгон ажиллаж 100% биелүүлсэн.
  - Секцийнхээ залуу багш нарыг аливааг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж сурахад чиглүүлэх, үлгэрлэн үзүүлэх, дагуулан сургах мөн өөрөө хамтран суралцаж зааж, заалгаж байна.
  - Цэнэглэх цагт тухай бүрд хамрагдаж , сурсан мэдсэнээ амьдрал ахуйдаа үр ашигтай ашиглаж хэрэгжүүлж байгаа.
2. Судлагдахууны хөтөлбөрийн үр дүн
- 10а-10д нийт 5 бүлэг 10 сонгох 11а,11в,11г бүлгүүд мөн 11сонгох -ангиудын нийт 10 бүлэгт стандартын дагуу хөтөлбөрөө боловсруулан баталгаажуулж сурагчдад хүргэлээ.
3. Журнал бичилт
- Цаг тухай бүрд нь Хичээлийн үйл ажилагааг анги бүрд хэрхэн зохион байгуулсан юу нь болов, юуг анхаарах талаар дэлгэрэнгүй дүгнэлт хийсэн.
  - Багшийн тэмдэглэл хэсэгт сурагчдыг ажиллуулах арга ,заавар зөвөлгөө тэмдэглэн бичин цаг тухайд нь дүгнүүлж байсан.
4. Хичээлд ордог сурагчдын хүртээмж
- 10 ба 11 дүгээр ангийн 8 бүлэг нийт-512 сурагчид, сонгон судлах хичээлийн нийт-89 сурагчдад хичээл орж байна. Өдөрт 5-6 цагийн хичээл заахад хүүхдийн тоо үнэхээр стандартаас давсан нь ачаалал их болж байгаа. Гэхдээ аль болох хүүхэд нэг бүрд хүрч ажиллахын тулд долоо хоног бүр сурагч нэг бүрийн дэвтэр шалган хичээл тэмдэглэл, өөрийн үнэлгээ, хичээл дугаарлалт, гэрийн даалгавар хийснийг нэг бүрчлэн шалгаж шаардлагатай үед эцэг эхтэй холбогдож ангийн багшаар дамжуулан харьцаж байлаа. Үүний үр дүнд сурагчид гэрийн даалгавараа хийж хэвшиж хичээлийн тэмдэглэлээ хөтөлж сурч байдаг.
- Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт
- Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт: Багшийн хөгжлийн дэвтрийг хийж гүйцэтгэсэн ажлын дагуу өдөр тутам хөтөлж, цаашид хийх ажлаа төлөвлөн тэмдэглэн дүгнэж, байгаа. Энэ дэвтэр тайлангаа бичихэд багш хөгжлийн дэвтрээ харж байгаад бичлээ. Хийсэн ажлын өдөр хоног алдалгүй тэмдэглэх нь андуурагдахгүй маш сайн байлаа.
  - Багш хөгжлийн дэвтрийн үзүүлэлт бүрээр, өдөр тутам хийх ажил болон хийгдсэн хамрагдсан ажлаа дэлгэрэнгүй бичиж сургалтын албаар дүгнүүлж байсан.
5. Хүүхэд бүрийн ахиц амжилтад нөлөөлсөн бүтээлч ажил
- Боловсролын үнэлгээний сайтан дээр байрлуулсан даалгаврын сантай ажиллуулж, сурагч нэг бүрээр тестийн санг хэвлүүлэн авч гарын авлага болгон ажиллуулсан.
- II. Авьяасыг нээн судлах хөгжүүлэх**
1. Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал
- Биологийн хичээлээрээ “Биологи бидний амьдралд нэртэй бүтээлийн үзэсгэлэн гаргасан.”
  - Дэвжээ тэмцээн болон ДОХ-Н эсрэг өдрүүдээр сурагчидаар ханын сонин гаргуулж түүгээрээ үзэсгэлэн гаргасан.
2. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлсэн байдал /дүүрэг/
- 10 ба 11 дугаар ангийн сурагчдад биологийн олимпиадын даалгавар дээр ажиллах сургалт давтлага ажлыг хийн энэ жил нийтдээ 56 сурагчыг биологийн олимпиадад орууллаа. Үүнээс 11в ангийн сурагч Б.Хулан 11б ангийн сурагч Оюун нар Алт Хүрэл медаль авлаа.

7. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал.
  - Ногоон гэрэл цагаан шугам Дэд байр
  - Биологи бидний амьдралд сэдэвт ханын сонин гаргасан.
  - Хэлний наадмаар Орос болон герман хэлний самбарууд дээр ажилласан.
  - Бусад үйл ажиллагаануудыг зураг хэлбэрээр хавсаргасан болно.
8. Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал
  - Мүүдл системийн сургалтыг тухай бүрд нь эзэмшиж нэг, ээлжит хөтөлбөр оруулах,эцэг эх болон сурагчдад даалгавар,мэдээлэл өгөх ,ангийн танилцуулга бичлэг хийн байршуулах, “Бар” код авах,бар кодоор мэдээлэл авах зэрэгт суралцсан.
  - Цахим хэрэглэгдэхүүнтэй хичээл бэлтгэн явуулж байгаа.
  - Бие бялдрын сорилд нормит үзүүлэлтийг гүйцэтгэх бэлтгэл ханган сорилыг 12 оноотой D үнэлгээтэй өгсөн
  - Цэнэглэх цагаар “Луужин стратеги” 2019-10-17 сургалтад хамрагдсан.
  - БМДИ газраас “Багшийн хөгжил” сургалт зохион байгуулж багш хөгжлийн дэвтэрийг хөтлөх талаар заавар зөвөлгөө өгсөн.
  - Цэнэглэх цагаар “Эрүүл мэнд- гоо сайхан” сургалтад хамрагдсан
  - Цэнэглэх цагаар “Эрүүл зөв дадал хэвшил ” сургалтад хамрагдсан
  - Шинэ монгол сургууль дээр “Молекул биологи ” онолын сургалт
  - Үе тэнгийнхний дээрэлхэлт сургалтанд хамрагдсан.
  - Цэнэглэх цагаар “Эко-орчин ” сургалтанд хамрагдсан.
  - Цэнэглэх цагаар “Авилгагүй ил тод орчин” сургалтанд хамрагдсан.
  - Цэнэглэх цагаар “Банш нарын 7 дугаар их хурлын” мэдээлэлд хамрагдсан.
  - Цэнэглэх цагаар “Эрүүл шүд-Эрүүл бие” сургалтанд хамрагдсан.

### **III. Боловсролын сэтгэл ханамж**

1. Цаг ашиглалт
  - Дэвтэртэй ажиллах, даалгаврыг нэг бүрчлэн шалгах
  - Журналт бичилт хийх , Багшийн хөгжлийн дэвтэр хөтлөх , Хичээл заах
  - Цаг үеийн хурал ,цуглаанд, Цэнэглэх цагт хамрагдах, Хяналтын ажил засах
  - Олимпиад уралдаан тэмцээнд сурагчдаа бэлтгэн явуулах, өөрөө засалтанд явах, сурагчдаа цаг үеийн үйл ажиллагаанд бэлдэх ,Цаг үеийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох.
  - Багш нарын хичээлд суух, хамтран бэлтгэлцэх,хэлэлцүүлэх зохион байгуулах
  - Сурагчдад эерэг болон хэрэгцээт сургалт /танхимын бус/ явуулах
  - Хүүхдийн сурах эрүүл ,аюулгүй орчин бүрдүүлэх.
  - Эцэг эхийн хурал зохион байгуулах, судалгаа авах .
  - Мүүдлийн сургалтанд хамрагдах
  - Жижүүр багш хийх ,
  - ЗАН-ийн хурал болон цаг үеийн ажилд хамрагдах
  - Нэгжийн болон улирлын шалгалт авч засах дүнг оруулах
2. Хичээлийн цагийн хариуцлага-40 минут
  - Хуваарьт хичээлээ хуваарийн дагуу цагтаа эхлүүлж эхлээд гэрийн даалгаврын шалгадаг.
  - Мөн ангийн чадварт тохируулан гэрийн даалгавар өгөж, цагаа баримтлан завсарлаж хэвшсэн байгаа.
3. Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт
  - Багш хүний баримтлах ёс зүй, хууль эрх зүйгээ баримтлан ажиллаж байгаа.
  - Тухайн анги ,сурагчдын нас биений онцлог зан аашны өөрчлөлтийг ШУ-ны үүднээс судалж тохирсон аргаар нь харьцан ёс зүйг дээдлэн сэтгэл ханамжтай ажиллалаа.
4. Багшийн хичээлийн бэлтгэл

- Хичээлийн цагийг баримтлан, хичээл бүрийг бэлдэн, чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажилласан
  - Улирал бүрийн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан сургалтын албаар батлуулж хичээлдээ орж байсан.
  - Сэдвүүдийн дагуу даалгаврын санг бүрдүүлэн Мүүдэлд байрлуулсан.
  - Боловсролын газраас жишиг болгон гаргасан “Даалгаврын санг” Мүүдэлд байрлуулж сурагчдаа тэндээс хэвэлж аван гартаа барихийг зөвлөсөн байгаа.
5. Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал
- Багшийн журналыг бүрэн бичилт хийж , Багшийн хөгжлийн дэвтрийг өдөр тутам хөтлөн заагдсан хугацаа бүрд нь сургалтын албаар үнэлүүлж хэвшсэн.
6. Сургалтын техник хэрэгслийг ашигласан байдал
- Мүүдл системийн сургалтыг тухай бүрд нь эзэмшиж нэг, ээлжит хөтөлбөр оруулах,эцэг эх болон сурагчдад даалгавар,мэдээлэл өгөх ,
  - Цахим хэрэглэгдэхүүнтэй хичээл бэлтгэн явуулж байгаа.
  - “Цахим” орчин үүсгэн хэрэглэж сурсан.
  - Мүүдл системд 3 ба 4 дүгээр улиралын 10 дугаар ангийн нэгж болон ээлжит хичээлийг байрлуулж мөн түүний дагуу шалгалт авах тестийг боловсруулан оруулсан.
  - Сэдвүүдийн дагуу даалгаварын санг бүрдүүлэн Мүүдэлд байрлуулсан.
  - Боловсролын газраас жишиг болгон гаргасан “Даалгаварын санг” Мүүдэлд байрлуулж сурагчдаа тэндээс хэвлэж аван гартаа барихийг зөвлөсөн байгаа.
  - Өөрийн нөөтбүүк дээр шаардлагатай программ ашиглан боловсруулалт хийж сурсан.

#### **IV. Эрүүл мэнд**

1. Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа
- Сурагчдын эрүүл харилцаа бий болгох
  - Багш сурагчдын эрүүл зөв харилцаах эрхэмлэн ажиллаж байгаа
  - Багш өөрөө сурагчийн нэр хүндийг хүндэтгэн харьцаж тэдэнтэй эелдэг уур амьсгал бий болгох арга чадварт суралцаж ажилласан
  - Өөрийн суудаг орчинг хариуцан цэвэр орчинд хичээлэлхийн тулд сурагч бүр сэтгэлтэй байх хэрэгтэйг анхааруулдаг
2. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал
- Дөрөв дүгээр цагийн завсарлагаанаар хичээл орж буй ангитайгаа Гимнастик хийж хэвшсэн.
  - Зөв суух дадалд хичээл ордог ангийн сурагчдыг зөв суухын ашиг тусыг Шинжлжх ухаанй үндсийг таниулан зөвлөн хичээл бүр дээр сануулан ажиллаж байна.
  - Ангийн сурагчдыг улирал бүр салаа хооронд байрлалыг солих, өдөр бүр урагш ахих замаар байрыг солин харааны нэг өнцөг тогтохоос сэргийлэн ажиллаж байна.
  - Хичээлийн явцад сурагчид ядарсан, хичээлийн идэвхий буурсан үед эрүүл мэндэд хэрэгтэй, дасгал хөдөлгөөн хийлгэдэг
  - *Эрүүл мэндэд хэрэгтэй алга ташилт, Нүдний дасгал, Толгой сэргээх дасгал...*
  - Хичээлд ирц, дүрэмт хувцас, хичээлд үс боох, бохь зажлахгүй байх шаардлагуудыг ямагт тавин ажилладаг.
3. Эрүүл мэндийн сургалт зохион байгуулж гарсан үр дүн
- Ахлах ангийн нийт сурагчдын дунд сургуулийн эмчтэй хамтран Бидний мэдэх ёстой зүйл гарын авлагаар сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэнд болон хар тамхи хүний наймаа сэдвүүдээр сургалт зохион байгуулж тайланг сургуулийн эмчид өгсөн байгаа.
4. Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал
- Хичээл ордог анги бүрдээ хичээл эхлэхийн өмнө 2 минут ангийн ариун цэврийн талаар шаардлага тавин ажилладаг.

5. Эрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал
- Ахлах ангийн биологийн хөтөлбөрийн хүрээнд 4-р бүлэг сэдэв нь халдварт ба халдварт бус өвчин гэсэн агуулга орсон бөгөөд уг агуулгын хүрээнд нийт ахлах ангийн сурагчдад халдварт өвчний талаархи сургалтуудыг хичээл сургалын үйл ажиллагаагаараа өгсөн.

**Биологийн секцийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:**



Биологийн хичээлээр бүтээлийн үзэсгэлэн 8-10 дугаар ангийн дунд гаргасан байдал



Нийслэлийн хэмжээнд Хүнсний хаягдал бүтээгдэхүүнээр органик бордоо хийх төсөлт ажил багын дүнгээр нийслэлд 3-р байр



Ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан яг одоо шинжилгээнд сэдэвт дэвжээ тэмцээн багын дүнгээр 3-р байр



Усны өдөр зориулсан дэвжээ тэмцээн миний бие шүүгчээр ажилласан. Чингэлтэй дүүргийн 12 сургуулийн дунд.



Дүүргийн биологийн олимпиад



Бидний мэдэх ёстой зүйл гарын авлагын танилцуулга хамтын ажиллагаа